



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/81

Бодь

Баяр наадам зохион байгуулах салбар  
комисс байгуулах тухай

Монгол Улсын Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 815, 816, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсаны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн баяр наадмыг 2022 оны 07 дугаар сарын 09,10-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2.Баяр наадмын бэлтгэл ажлыг хангуулах салбар хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, баяр наадмын хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Баяр наадмын хурдан морь, үндэсний бөхийн барилдааныг хууль, журмын дагуу зохион байгуулахыг салбар комиссын дарга нарт үүрэг болгосугай.

4. Баяр наадмын үеэр архидан согтуурч автотехникийн осол аваар, гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, худалдаа үйлчилгээний газруудын хяналт шалгалтыг эрчимжүүлэн, хурдан морь дагах автомашины тоонд хязгаарлалт тогтоож зөвшөөрөл олгохыг хурдан морины салбар комиссын дарга (Н.Сумъяа), хэв журмын салбар комиссын дарга (М.Цэнд-Аюуш), Морь унаач хүүхдийг хамгаалах хэрэгсэл өмсүүлж, гэнэтийн ослын даатгалд заавал хамруулах арга хэмжээг зохион байгуулан уяач нарт танилцуулж унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангахыг Нийгмийн бодлогын ажилтан (Б.Хандсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

5.Баяр наадмын үйл ажиллагаанд шаардагдах айраг, цагаан идээ, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг аж ахуйн салбар комиссын дарга (Т.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.

6.Баяр наадмын нээлт, хаалтын үйл ажиллагаа, урлаг соёлын арга хэмжээг тусгай хөтөлбөр гаргаж, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж


642201153

ажиллахыг Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Болортуяа)-д үүрэг болгосугай.


7.Салбар комиссын бүрэлдэхүүний үйл ажиллагаанд хариуцлагагүй хандаж, өгөгдсөн үүрэг чиглэлийг биелүүлж ажиллаагүй төрийн албан хаагч нарт хариуцлага тооцож ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа), Тамгын газрын дарга (Т.Эрдэнэцэцэг) нарт даалгасугай.

8.Наадмын үйл ажиллагаанд зарцуулагдах 5.000,000 (таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас гаргахыг Санхүү албаны дарга (П.Наранбаатар), Тусгай сан хариуцсан нягтлан бодогч (Т.Цэнд-Аюуш) нарт зөвшөөрсүгэй.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Р.БАТЖАРГАЛ

Сумын Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 07  
өдрийн 14-д тоот захирамжийн нэгдүгээр хавсралт



## БАЯР НААДМЫН САЛБАР КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Аж ахуйн комисс:

Комиссын дарга

Т.Эрдэнэцэцэг-ТГ-ын дарга

Гишүүд

М.Бибиш-Сургуулийн захирал

Ц.Цэрэнхүү-Эрүүл мэндийн төвийн дарга

Б.Болортуяа-Соёлын төвийн дарга

Б.Өлзийдүүрэн-Цэцэрлэгийн эрхлэгч

П.Наранбаатар-Санхүү албаны дарга

С.Ганцэцэг-Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Г.Оюунсүрэн-Татварын улсын байцаагч

П.Батбаатар-Байгаль хамгаалагч

Н.Жаргалсайхан-Улсын тусгай хамгаалалттай газрын  
байгаль хамгаалагч

Б.Баяраа-Бэлчээр, газар тариалан хариуцсан  
мэргэжилтэн

О.Баасанбат-Нийгмийн даатгалын байцаагч

Б.Цэдэвсүрэн-Төсөв төрийн сангийн мэргэжилтэн

Б.Тунгалаг-Улсын бүртгэгч

М.Оюунбилэг-Архив, бичиг хэргийн эрхлэгч

Д.Батболд-Жолооч

Л.Ганболд-Нярав

Ц.Бямбасүрэн-Үйлчлэгч

Ж.Лхагвасүрэн-1 дүгээр багийн Засаг дарга

Д.Наранбаатар-2 дугаар багийн Засаг дарга

У.Батцэцэг-3 дугаар багийн Засаг дарга

Б.Мөнхбат-4 дүгээр багийн Засаг дарга

Б.Ганцэцэг-5 дугаар багийн Засаг дарга

А.Чулуунбат-Тохижилт үйлчилгээний ажилтан

Х.Цогт-Очир-Тохижилт үйлчилгээний ажилтан

Үндэсний бөхийн комисс:

Комиссын дарга: Г.Эрдэнэтөр-Тархвар зүйч

Гишүүд: О.Батдорж-ИТХ-ын төлөөлөгч

Ц.Отгонбат-Нийтийн биеийн тамирын арга зүйч

Х.Чонцол-Их эмч

Б.Батчулуун-ИТХ-ын төлөөлөгч

Хурдан морины комисс:

Комиссын дарга: Н.Сумъяа-Засаг даргын орлогч

Гишүүд: Ц.Цэрэнхүү-Эрүүл мэндийн төвийн дарга

Б.Алтанхуяг-Үржил бүртгэл технологи хариуцсан  
мэргэжилтэн

Т.Цэнд-Аюуш-Тусгай сан хариуцсан нягтлан бодогч

Б.Хандсүрэн-Нийгмийн бодлогын ажилтан

А.Лхагвабаяр-Мал эмнэлгийн улсын байцаагч

А.Чулуунбат-Тохижилт үйлчилгээний ажилтан

Х.Цогт-Очир-Тохижилт үйлчилгээний ажилтан

Сурын харвааны комисс:

Комиссын дарга: Н.Хорлоо-Газрын даамал

Гишүүд Х.Баттогтох-Сургуулийн ажилтан

Б.Хандсүрэн-Нийгмийн бодлогын ажилтан

Шагайн харвааны комисс

Комиссын дарга: Ц.Төмөрбат-Эрүүл мэндийн төвийн нягтлан

Гишүүд: Б.Батбаяр-Тамгын газрын нягтлан бодогч

А.Нямдорж-Эрүүл мэндийн төвийн бичиг хэргийн  
ажилтан

Ц.Бат-Өлзий-Хөгжмийн боловсролын багш

М.Мөнхбаатар-Цэцэрлэгийн ажилтан

Хэв журмын комисс:


Комиссын дарга: М.Цэнд-Аюуш-Хэсгийн төлөөлөгч

Э.Даваацэрэн-Хэсгийн цагдаа

Сум дундын цагдаагийн тасаг

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Сумын Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 09 өдрийн  
1/24 тоот захирамжийн хоёрдугаар хавсралт



## БАЯР НААДМЫН ХӨТӨЛБӨР

2022 оны 07 дугаар сарын 09

- 05<sup>00</sup> цагаас Хурдан азарганы уралдаан
- 07<sup>00</sup> цагаас Хурдан их насны морьдын уралдаан
- 09<sup>30</sup> цагаас Хурдан Соёолон насны морьдын уралдаан
- 11<sup>30</sup> цагаас Хурдан хязаалан насны морьдын уралдаан
- 13<sup>00</sup> цагаас Хурдан шүдлэн насны морьдын уралдаан
- 14<sup>00</sup> цагаас Хурдан дааганы уралдаан
- 16<sup>00</sup> цагаас Баяр наадмын нээлтийн үйл ажиллагаа
- 17<sup>00</sup> цагаас Үндэсний бөхийн барилдаан (1-ийн даваа)
- 20<sup>00</sup>-00<sup>00</sup> цаг хүртэл Урлаг соёлын арга хэмжээ

2022 оны 07 дугаар сарын 10

- 08<sup>00</sup> цагаас Үндэсний бөхийн барилдааны үргэлжлэл (2,3,4-ын даваа)
- 12<sup>00</sup> цагаас Үндэсний Сурын харваа (Наадмын талбай)
- 12<sup>00</sup> цагаас Үндэсний Шагайн харваа (Наадмын талбай)
- 13<sup>00</sup> цагаас Цолгүй бөхчүүдийн барилдаан
- 14<sup>00</sup> цагаас Хүүхдийн барилдаан (7-9, 10-12, 13-15 насны ангилал)
- 15<sup>00</sup> цагаас Ардын хувьсгалын 100 жилийн ойн медаль гардуулах
- 16<sup>00</sup> цагаас Үндэсний бөхийн барилдаан (5-ын даваа)
- 17<sup>00</sup> цагаас Үндэсний сур, шагайн харвааны шагнал гардуулах
- 17<sup>30</sup> цагаас Түрүүлж, айрагдсан морьдын шагнал гардуулах
- 18<sup>30</sup> цагаас Үндэсний бөхийн үзүүр, түрүүний барилдаан
- 19<sup>00</sup> цагаас Шагнал гардуулах
- 19<sup>30</sup> цагаас Баяр наадмын хаалтын үйл ажиллагаа
- 20<sup>00</sup> цагаас Үдшийн цэнгүүн

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_